



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

**“Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”
батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 16 дугаар зүйлийн 16.2, 62 дугаар зүйлийн 62.2, 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын 1-д заасан журмыг баталсантай холбогдуулан өөрийн байгууллагын дүрэм, журамд зохих өөрчлөлтийг оруулж, 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хороогоор батламжлуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Монголын үнэт цаасны бирж” ХК /Ж.Золзаяа/, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК /О.Эрдэнэгэрэл/, “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ТББ /Б.Өлзийбаяр/, журмын хэрэгжилтийг хангаж, чанд мөрдөж ажиллахыг нийт зохицуулалттай этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.
3. Өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд нийтэд санал болгох, худалдах ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани дангаараа болон хамтран зохион байгуулахтай холбогдуулан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т заасан тодорхойлолт, 12.5-д заасан дүгнэлтийг тухай бүр гаргаж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Монголын үнэт цаасны бирж” ХК /Ж.Золзаяа/-д тус тус үүрэг болгосугай.
4. Компанийн өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд нийтэд санал болгох, худалдах ажиллагаа, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан өөрийн гишүүн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компанийн хүний нөөц, санхүүгийн чадавхыг сайжруулж, ёс зүйн дүрэм, журмыг чанд мөрдүүлэн ажиллахыг “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ТББ /Б.Өлзийбаяр/-д даалгасугай.
5. Тогтоолын 1-д заасан журмыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмаар компанийн өрийн хэрэгсэл /цаашид “бонд” гэх/-ийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, нийтэд санал болгон гаргах бондыг анхдагч зах зээлд санал болгох, худалдах, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх, бонд гаргагч, зохицуулалттай этгээд, Хорооны эрх, үүрэг болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон энэ журмын 3.2-т зааснаас бусад Биржийн бус зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгох бондын бүртгэлтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.3. Энэ журмын 3.2-т заасан бондыг анхдагч зах зээлд санал болгох, худалдах, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.4. Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсын хөрөнгийн биржид бонд гаргаж бүртгүүлэх тохиолдолд Хороонд мэдэгдэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.5. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондыг бүртгэхтэй холбоотой харилцааг Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмаар, бусад харилцааг энэ журмаар зохицуулна.

1.6. Хаалттай хувьцаат компанийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй нийтэд санал болгох бондын бүртгэлтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР. НИЙТЭД САНАЛ БОЛГОН БОНД ГАРГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Бонд гаргагч нь дараах шалгуур, шаардлагыг бүрэн хангасан байна:

2.1.1. хаалттай хувьцаат компани, эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй бол гурваас доошгүй жилийн өмнө үүсгэн байгуулагдсан, Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

2.1.2. Хороонд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

2.1.3. хөрөнгө оруулагчдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэг байх;

2.1.4. өмнө нь нийтэд санал болгон бонд гаргасан этгээд бол хоёр болон түүнээс дээш удаа бондын хүүгийн болон үндсэн төлбөрийг тогтсон хугацаанаас хоцроож, төлбөрийн тасалдал учруулж байгаагүй;

2.1.5. энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй нийтэд санал болгох бонд гаргагч нь хувьцаат компани хэлбэртэй байх;

2.1.6. үйлчилгээ үзүүлэх андеррайтерийн компанийн холбогдох этгээд биш байх.

2.2. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий андеррайтерийн компаниас бусад бонд гаргагч нь андеррайтерийн компанитай 'Андеррайтерийн гэрээ' байгуулсан байна.

2.3. Дараах этгээдийн нийтэд санал болгон гаргах бондыг бүртгэх асуудлыг Хороо ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

2.3.1. арилжаа эрхлэх байгууллагын I ангилалд хувьцаа нь бүртгэлтэй;

2.3.2. Монгол Улсын Засгийн газраас, эсхүл Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагаас баталгаа гаргасан;

2.3.3. Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгжээр сүүлийн гурван жилийн хугацаанд нэг болон түүнээс дээш удаа шалгарсан;

2.3.4. Монгол Улсын Хөгжлийн банк;

2.3.5. хоёр болон түүнээс доошгүй удаа нийтэд санал болгон бонд гаргаж байсан бол үндсэн болон хүүгийн нийт төлбөрийг бүрэн төлж дууссанаас хойш 12 сар өнгөрөөгүй.

2.4. Бонд гаргагчид Засгийн газар, эсхүл энэ журмын 2.1-д заасан шалгуурыг хангасан гуравдагч этгээд баталгаа гаргасан бол тухайн этгээдэд энэ журмын 2.1.1 дэх заалт хамаарахгүй.

2.5. Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийг хангах өөрийн, эсхүл гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан барьцаа, баталгаа, батлан даалттай байж болох бөгөөд энэ журмын 2.6-д зааснаас бусад тохиолдолд барьцаа хөрөнгө нь бонд гаргагчийн гаргасан, энгийн хувьцаа эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна.

2.6. Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан дааж болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас дээшгүй байна.

2.7. Энэ журмын 2.6-д заасны дагуу батлан даасан хувьцааны үнэлгээг тогтоохдоо арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзах бөгөөд барьцаалах үнэлгээ нь тухайн хувьцааны үнэлгээний 70 хувиас илүүгүй байна.

2.8. Бонд гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно.

2.9. Бонд гаргагч нь энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол Хороо бондыг бүртгэхээс татгалзах ба татгалзсан шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган бонд гаргагчид энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. БОНДЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БҮРТГЭХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

3.1. Бонд гаргагч нь нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бондыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.1.1. албан хүсэлт, бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1/;

3.1.2. арилжаа эрхлэх байгууллагын 'Бүртгэв' тэмдэглэл бүхий бондын танилцуулга /2 эх хувь/;

3.1.3. андеррайтерийн компанитай байгуулсан гэрээ, Хороонд гаргасан андеррайтерийн тодорхойлох захидал;¹

3.1.4. хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн 6 сараас дээшгүй хугацааны санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан аудиторын Хороонд гаргасан тодорхойлох захидал;

3.1.5. бонд гаргагчид гуравдагч этгээд барьцаа, баталгаа, батлан даалт гаргасан бол талуудын байгуулсан гэрээ;

3.1.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

3.2. Нийтэд санал болгон гаргасан бонд нь Хороонд бүртгэлтэй байгаа хуулийн этгээд болон нээлттэй хувьцаат компанийн хаалттай хүрээнд шинээр гаргах бондыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.2.1. албан хүсэлт, бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 2/;

3.2.2. бонд гаргагчийн хаалттай хүрээнд бонд гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.2.3. гуравдагч этгээд барьцаа, баталгаа, батлан даалт гаргасан бол тухайн барьцаа, баталгаа, батлан даалттай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр, бонд гаргагчтай байгуулсан гэрээ;

3.2.4. биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай мэргэжлийн холбооны шийдвэр;

3.2.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.3. Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд нь гадаад улсын хөрөнгийн биржид бондоо бүртгүүлэх бол дараах баримт бичгийг Хороонд хүргүүлж, мэдэгдэнэ:

3.3.1. албан бичиг, мэдэгдэл /Хавсралт 3/;

3.3.2. бонд гаргагчийн гадаад улсад бонд гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.3.3. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

3.4. Бондын танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5-д зааснаас гадна дараах болон шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг тусгасан байна:

3.4.1. бонд гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.4.2. бонд гаргагчид гуравдагч этгээд хөрөнгөө барьцаалуулсан, баталгаа гаргасан бол дараах мэдээллийг тусгана:

3.4.2.1. тухайн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.4.2.2. тухайн этгээдийн тухай мэдээлэл болон хуулийн этгээд бол сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан.

3.4.3. бонд гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийн хооронд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл;

¹ Андеррайтерийн тодорхойлох захидалд бонд гаргагчийн нийтэд санал болгон гаргах бондыг анхдагч зах зээлд байршуулж, хөрөнгө оруулагчдад худалдахад ашиглах арга, хэлбэр, бондын танилцуулга болон бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн талаар болон бонд гаргагчийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх талаар гаргасан баталгаа зэрэг мэдээллийг тусгасан байна.

3.4.4. сүүлийн 3 жилийн болон 6 сараас дээшгүй хугацааны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт;

3.4.5. бонд гаргахтай холбоотой гаргасан зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулах бол энэ тухай мэдээлэл;

3.4.6. энэ журмын дөрөвдүгээр бүлэгт заасан “Бонд гаргах хөтөлбөр” хэрэгжүүлэх бол татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, шаардлагатай бусад мэдээлэл;

3.4.7. энэ журмын 3.6-д заасан бондын гэрээний үндсэн нөхцөл;

3.4.8. ногоон бонд гаргах бол бонд гаргагчийн үйл ажиллагааны ерөнхий стратеги, татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, удирдлага, тайлагналын үйл явц, хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэсэн эсэх болон шаардлагатай бусад мэдээлэл бүхий “Ногоон танилцуулга” /Хавсралт 4/;

3.4.9. ногоон бонд гаргагчийн санхүүжүүлэх үйл ажиллагаа эсхүл үйлдвэрлэх эцсийн бүтээгдэхүүн нь “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” болохыг баталгаажуулах зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулсан бол уг дүгнэлт;

3.4.10. дараах сануулгыг эхний хуудсанд тодоор бичсэн байна:

“Энэхүү танилцуулгад тусгасан бондыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг үнэт цаасанд гаргасан аливаа баталгаа биш бөгөөд түүний агуулсан аливаа мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг Хороо хариуцахгүй!

Үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, бондын танилцуулга, бонд гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

3.5. Бондын танилцуулгыг бонд гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, андеррайтерийн компанийн гүйцэтгэх захирал тус тус гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.6. Бондын үндсэн нөхцөл бүхий Бондын гэрээг бичгээр байгуулах бөгөөд уг гэрээг нэг талаас бонд гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлөн андеррайтер байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.7. Энэ журмын 3.6-д заасан Бондын гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна.

3.7.1. бондын нэрлэсэн үнэ, тоо, хугацаа, төрөл, хүүгийн төрөл, түвшин, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хуваарь;

3.7.2. хүүгийн төлбөрийг тооцоолох аргачлал;

3.7.3. барьцаа, баталгаа, батлан даалтын тухай;

3.7.4. энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бол хөрвүүлэх нөхцөл, журам;

3.7.5. хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдах, худалдан авах нөхцөлтэй бол нөхцөл, журам;

3.7.6. бонд гаргагчийн санхүүгийн чадавхыг сайжруулахтай холбоотой нэмэлт мэдээлэл;

3.7.7. бонд гаргагч мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх давтамж, хэлбэр;

3.7.8. хөрөнгө оруулагчийн болон бонд гаргагчийн эрх, үүрэг, хариуцлага;

3.7.9. бонд гаргагчид хориглох зүйлс;

3.7.10. бонд гаргагчид хориглоогүй, хэрэгжүүлж болох бусад зүйлс;

3.7.11. төлбөрийн тасалдал /дефолт/ болсонд тооцох нөхцөлийг тодорхойлох бөгөөд тухайн нөхцөл үүссэн тохиолдолд санхүүгийн чадавхыг сайжруулах арга зам, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх журам;

3.7.12. төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөлийг тодорхойлох бөгөөд тухайн нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг хэрэгжүүлэх журам;

3.7.13. шаардлагатай бусад.

3.8. Нийтэд санал болгон гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг барьцаалах бол барьцааны гэрээг нэг талаас бонд гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлөн андеррайтер байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.9. Бонд гаргагч нь энэ журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж, Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.

3.10. Нийтэд санал болгон гаргах бонд, түүний танилцуулгыг бүртгэх эсэх асуудлыг Хороо тухайн бонд гаргагчаас ирүүлсэн бондын танилцуулга, бусад баримт бичиг болон арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн дүгнэлт зэргийг хянаж, ажлын 20 өдөрт шийдвэрлэнэ.

3.11. Энэ журмын 2.3-т заасан этгээдийн нийтэд санал болгон гаргах бонд, түүний танилцуулгыг бүртгэх эсэх асуудлыг Хороо тухайн бонд, түүний танилцуулгыг бүртгэсэн тухай арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн ажлын 10 өдөрт шийдвэрлэнэ.

3.12. Энэ журмын 3.2-т заасан этгээдийн гаргах хаалттай бондыг бүртгэх эсэх асуудлыг Хороо тухайн бондыг биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай мэргэжлийн холбооны шийдвэрийг үндэслэн ажлын 10 өдөрт шийдвэрлэнэ.

3.13. Бонд гаргагчийн ирүүлсэн баримт бичиг нь агуулгын хувьд дутуу, зөрүүтэй, тодорхойгүй тохиолдолд Хороо нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга ирүүлэхийг бонд гаргагчид мэдэгдэнэ.

3.14. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид болон энэ журамд заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлтэй гэж үзвэл бондыг бүртгэхээс татгалзаж, бонд гаргагчид энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

3.15. Хороо бондыг бүртгэсэн тухай шийдвэрийг бонд гаргагч, андеррайтер, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон арилжаа эрхлэх байгууллага эсхүл мэргэжлийн холбоонд тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

3.16. Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн бондын танилцуулга тус бүрд Хорооны “Бүртгэв” тэмдэглэл хийж арилжаа эрхлэх байгууллага болон Хороо тус тус нэг хувийг хадгалах бөгөөд бонд гаргагч болон андеррайтерт мөн тэмдэглэгээ бүхий танилцуулга шаардлагатай бол тэдгээрийн гаргасан хүсэлтийг үндэслэн зохих тэмдэглэгээг эх хувь тус бүрд хийж, хүргүүлнэ.

3.17. Хаалттай хувьцаат компани нь энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондыг Хороонд бүртгүүлсэн бол түүний хөрвөх энгийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад ажлын 10 өдрийн дотор бүртгүүлнэ.

3.18. Хороо энэ журмын 3.3-т заасан мэдэгдлийг хүлээн авсан тухай албан бичгийг ажлын гурван өдрийн дотор тухайн үнэт цаас гаргагчид хүргүүлнэ.

3.19. Энэ журмын 3.3-т заасан этгээд нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн, эсхүл бүртгэлээс хасуулсан тохиолдолд тус тус тухайн байгууллагын шийдвэрийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

3.20. Бонд гаргагчийн гаргасан бондын төлбөрийн тасалдал болж, бондын танилцуулга, гэрээнд заасан нөхцөлд өөрчлөлт оруулах бол бондын бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.21. Бондын бүртгэлд өөрчлөлт оруулахад дараах баримт бичгийг Хороонд, бонд нь бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын журамд заасан баримт бичгийг тухайн байгууллагад тус тус зэрэг хүргүүлнэ:

3.21.1. үндэслэл бүхий албан хүсэлт;

3.21.2. өмнө хийсэн болон хийх шаардлагатай төлбөрийн мэдээлэл;

3.21.3. бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр авсан арга хэмжээний тухай мэдээлэл;

3.21.4. бондын гэрээнд заасан нөхцөлд өөрчлөлт оруулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.21.5. бондын танилцуулгад орсон өөрчлөлтийн тухай дэлгэрэнгүй мэдэгдэл;

3.21.6. бондын гэрээний төсөл;

3.21.7. бонд гаргагчийн шаардлагатай гэж үзсэн бусад.

3.22. Бондын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт, холбогдох баримт бичгийг Хороо хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянаж, бүртгэлд өөрчлөлт оруулсан тухай холбогдох этгээдийн шийдвэрийг үндэслэн бондын бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.23. Хороо бондыг дараах тохиолдолд бүртгэлээс хасна:

3.23.1. бонд гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлсөн;

3.23.2. бонд гаргагч нь бондын гэрээнд заасны дагуу нийт гаргасан бондын тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч, эсхүл бонд эзэмшигч хөрөнгө оруулагч нь бонд гаргагчид нийт гаргасан бондын тодорхой хэсгийг эргүүлэн худалдаж, тухайн бондыг бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан;

3.23.3. хөтөлбөр хэрэгжүүлж, тэргүүн ээлжид гаргасан бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлсөн;

3.23.4. нийтэд санал болгох бондыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сарын дотор танилцуулгад заасан хэмжээгээр анхдагч зах зээлд санал болгоогүй, эсхүл санал болгосон боловч уг үйл ажиллагаа амжилтгүй болсон;

3.23.5. шүүх болон эрх бүхий төрийн байгууллагаас бонд гаргагчийг татан буулгах шийдвэр гаргасан.

3.24. Бонд гаргагч нь бондыг бүртгэлээс хасуулахад арилжаа эрхлэх байгууллагын, эсхүл мэргэжлийн холбооны бүртгэлээс тэргүүн ээлжид хасуулсан байна.

3.25. Бонд гаргагч энэ журмын 3.1-д заасан буюу нийтэд санал болгон гаргасан бондыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасуулахад дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ:

3.25.1. албан хүсэлт;

3.25.2. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай мэдэгдэл, холбогдох баримт;

3.25.3. бондыг энгийн хувьцаанд хөрвүүлсэн бол үнэт цаас эзэмшигчийн өмчлөх эрх баталгаажсан тухай төвлөрсөн хадгаламжийн байгууллагын мэдэгдэл;

3.25.4. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.26. Энэ журмын 3.2-т заасан этгээд биржийн бус зах зээлд гаргасан бондыг бүртгэлээс хасуулахад дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ:

3.26.1. албан хүсэлт;

3.26.2. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай мэдэгдэл;

3.26.3. бондыг хассан тухай мэргэжлийн холбооны шийдвэр;

3.26.4. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.27. Хороо энэ журмын 3.25, 3.26-д заасан баримт бичгийн бүрдэл, агуулгыг ажлын 10 өдрийн дотор хянаж, холбогдох этгээдийн бүртгэлээс хассан тухай шийдвэрийг үндэслэн Хорооны бүртгэлээс хасах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.28. Нийтэд санал болгох бондыг анхдагч зах зээлд санал болгож, уг үйл ажиллагаа амжилтгүй болсон тохиолдолд захиалгыг цуцлах мэдэгдлийг андеррайтерт хүргүүлж, захиалгыг бүрэн цуцалснаас хойш ажлын таван өдрийн дотор бондын бүртгэлийг Хорооны хуралдаанаар хүчингүй болгоно.

3.29. Энэ журмын 3.23.5-д заасан шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор бондын бүртгэлийг Хорооны хуралдаанаар хүчингүй болгоно.

3.30. Хороо бондыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг бонд гаргагч, арилжаа эрхлэх байгууллага, эсхүл мэргэжлийн холбоо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, андеррайтерт тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан ажлын гурван өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

3.31. Андеррайтер нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд бонд гаргагчийн хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргийн мэдээллийг Хорооны шийдвэрийг үндэслэн тухай бүрд нийлүүлж, шинэчилнэ.

ДӨРӨВ. БОНД ГАРГАХ ХӨТӨЛБӨР

4.1. Энэ журмын 2.3 болон 5-д заасан этгээд нийтэд санал болгох тодорхой үнийн дүн бүхий бондуудыг бүхэлд /нийтэд/ нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгох Бонд гаргах хөтөлбөр /цаашид 'хөтөлбөр' гэх/-ийг хэрэгжүүлж болно.

4.2. Бонд гаргагч нь хөтөлбөр хэрэгжүүлэх тухайгаа бондын танилцуулгад тодорхой тусгана.

4.3. Хөтөлбөрийн хүрээнд санал болгох бондыг хэсэгчлэн гаргах бол анхны нийлүүлэлтийг энэ журмын 6.2-т заасан хугацаанд хийх ба бондыг Хороонд бүртгүүлснээс хойш дараах хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлж, үлдэх хэсгийг санал болгоно:

4.3.1. төслийн хөрөнгө оруулалт хийх зориулалттай бол 24 сарын дотор;

4.3.2. эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зориулалттай бол 18 сарын дотор;

4.3.3. бусад зориулалттай бол 12 сарын дотор.

4.4. Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгох нийт бондуудын тоо, татан төвлөрүүлэхээр зорьж байгаа хөрөнгийн хэмжээ, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх нөхцөл, үнэ, хүү нь харилцан адилгүй байж болно.

4.5. Хөтөлбөрийн хүрээнд бондыг анхдагч зах зээлд нийлүүлэх тухай бүрд энэ журмын 5.5-д заасан мэдэгдлийг Хороонд хүргүүлнэ.

4.6. Хороо энэ журмын 6.5-д заасан мэдэгдэл, хавсралт баримт бичгийг хүлээн авч ажлын гурван өдөрт хянах бөгөөд дараах тохиолдолд нийтэд санал болгох бондын захиалгын бүртгэлийг зогсоож болно:

4.6.1. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй;

4.6.2. энэ журмын 2.1.2-т заасан шаардлагыг хангаагүй;

4.6.3. төрийн эрх бүхий байгууллагаас, эсхүл хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагаас ногоон бонд гаргагч нь ‘ногоон’, ‘байгаль орчинд ээлтэй’ гэх ойлголтыг буруу ашигласан болохыг тогтоосон тухай, эсхүл уг шаардлагад нийцээгүй болсон бол энэ тухай олон нийтэд мэдээлээгүй бол.

4.7. Хөтөлбөрийн хүрээнд бүртгүүлсэн Бондын танилцуулгыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сар тутамд шинэчлэн Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

4.8. Энэ журмын 4.7-д заасан бондын шинэчилсэн танилцуулга нь бонд гаргагчийн бизнесийн орчин, санхүүгийн байдалд орсон өөрчлөлтүүд болон үүсч болзошгүй нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын шийдвэрт материаллаг нөлөө үзүүлэхүйц үйл явдал болсон, эсхүл болох нь тодорхой байгаа асуудлууд зэрэг бонд гаргагчийн шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл бүхий анх бүртгүүлсэн Бондын танилцуулгын нэмэлт-хавсралт хэлбэртэй байна.

ТАВ. НОГООН БОНД ГАРГАХ

5.1. Бонд гаргагч нь Монгол Улсын “Ногоон таксономи” эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу шинээр хэрэгжүүлэх эсхүл одоо хэрэгжүүлж байгаа төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор ‘ногоон бонд’ гаргаж болно.

5.2. Нийтэд санал болгон ногоон бонд гаргагч нь бонд гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа эсхүл үйлдвэрлэх эцсийн бүтээгдэхүүн нь “Ногоон таксономи” эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” болохыг баталгаажуулах зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулж болно.

5.3. Энэ журмын 5.2-т заасан хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

5.3.1. ногоон бонд гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаанд иж бүрэн үнэлгээ хийх туршлагатай;

5.3.2. байгаль орчны зорилтуудын төлөвлөлт, хэрэгжилт, биелэлтийг үнэлэх чиглэлээр мэргэшсэн;

5.3.3. ногоон бонд гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтан, зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээс хараат бус, аливаа сонирхлын зөрчилгүй;

5.3.4. олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагуудад зориулсан стандарт бүхий удирдамжийг мөрддөг, гэрчилгээжүүлэх системийн дагуу магадлан итгэмжлэгдсэн.

5.4. Ногоон бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг ногоон бонд гаргагч нь тусгай дансанд байршуулж, зөвхөн энэ журмын 5.1-т заасан зориулалтын дагуу ашиглана.

5.5. Бондын хугацаа дуусахад ногоон бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн дүн болон үлдэгдэл хөрөнгө нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээс багагүй байна.

5.6. Ногоон бонд гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, зарцуулалт, хөрөнгө хуваарилалт болон санхүүгийн тайланд жил бүр аудит хийлгэх ба хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулагч байгууллагаар дүгнэлт гаргуулсан бол тухайн татан төвлөрүүлсэн хөрөнгө бүрэн хуваарилагдаж дуусах хүртэлх хугацаанд жил бүр тухайн байгууллагаар ногоон үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргуулна.

5.7. Энэ журмын 8.6.3-т заасан Ногоон бондын тайланг хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллага хянан баталгаажуулж болно.

5.8. Ногоон бонд гаргагч нь энэ журмын 5.2, 5.6, 5.7-т заасны дагуу хөндлөнгийн баталгаажуулагч байгууллагыг авч ажиллуулсан бол хөндлөнгийн баталгаажуулагч байгууллагын гаргасан тайланг Ногоон бондын тайланд тусгаж, компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

5.9. Ногоон бонд гаргагч энэ журам эсхүл холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг зөрчсөн бол уг зөрчлийг арилгах чиглэлээр Хорооноос үүрэг өгөх бөгөөд гаргасан зөрчлийг арилгаагүй тохиолдолд Хороо энэ тухай холбогдох байгууллагууд болон олон нийтэд нэн даруй мэдэгдэнэ.

ЗУРГАА. БОНДЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЭХ

6.1. Хороо нийтэд санал болгон гаргах бондыг бүртгэх тухай шийдвэрээр тухайн бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэх болон анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг нэгэн зэрэг олгоно.

6.2. Бондыг анхдагч зах зээлд санал болгох, захиалга авах үйл ажиллагааг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сарын дотор гүйцэтгэнэ.

6.3. Андеррайтер нь бондыг танилцуулгад тусгасан нөхцөл, журамд заасан арга хэлбэрээр анхдагч зах зээлд санал болгоно.

6.4. Андеррайтер нь энэ журмын 6.3-т заасан ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад бондын талаар танилцуулж, санал болгож болно.

6.5. Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэх бөгөөд мэдэгдэл нь дараах агуулгатай байна:

6.5.1. захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа;

6.5.2. санал болгох бондын хэмжээ, үнэ;

6.5.3. санал болгох арга, хэлбэр.

6.6. Хөтөлбөр хэрэгжүүлж байгаа этгээд нь бондын нийлүүлэлтийг хийхэд энэ журмын 6.5-д заасан мэдэгдэлд дараах баримт бичгийг хавсаргана:

6.6.1. өмнөх улирлын санхүүгийн ерөнхий үзүүлэлт;

6.6.2. бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, мэдээлэл.

6.7. Анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагаа нь ажлын таван өдрөөс илүүгүй хугацаатай байна.

6.8. Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагааг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

6.8.1. захиалга авах;

6.8.2. танилцуулгад тусгасан бол авсан захиалгын үндсэнд үнэ тогтоох;

6.8.3. захиалгын хуваарилалтыг хийх.

6.9. Андеррайтер нь бондын хуваарилалтыг хийхдээ ижил нөхцөлтэй захиалга бүхий хөрөнгө оруулагчийн захиалгын хуваарилалтыг түүний захиалга өгсөн брокероос үл хамааран тэгш зарчмаар буюу цаг хугацааны дарааллаар, эсхүл хувь тэнцүүлэн хийж, байршуулна.

6.10. Бонд гаргагчийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энгийн хувьцаа эзэмшигч нь хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

6.11. Энэ журмын 6.10-д заасан эрхийг хэрэгжүүлэхэд бонд гаргагчийн энгийн хувьцаа эзэмшигчийн захиалгын эзэмшиж байгаа хувьцааны тоонд хувь тэнцэх хэсгийг тэргүүн ээлжид хуваарилах бөгөөд илүү гарсан захиалгын хуваарилалтыг энэ журмын 6.9-д заасан зарчмаар хийж байршуулна.

6.12. Бонд гаргагч нь варрант гаргаж хөрөнгө оруулагчид санал болгосон бол варрант эзэмшигч нь бонд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх тохиолдолд анхдагч зах зээлийн захиалга дуусахаас өмнө бондын зохих төлбөрийг гүйцэтгэнэ.

6.13. Андеррайтер нь бонд гаргагчтай тохиролцсоны үндсэн дээр бондыг анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд бондыг тогтоосон үнээр санал болгоно.

6.14. Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг авч дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор хуваарилалтыг хийн, тайлан /Хавсралт 5/-г арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ.

6.15. Бондыг анхдагч зах зээлд санал болгон худалдах үйл ажиллагаа амжилттай болсон тухай мэдэгдлийг Хороо андеррайтерт хүргүүлэх хүртэлх хугацаанд татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг бонд гаргагчийн холбогдох дансанд тусгаарлан байршуулна.

6.16. Андеррайтер нь захиалгын бүртгэлийн аргаар бондын захиалгыг бүрдүүлэх тохиолдолд үнийг бонд гаргагчийн саналыг харгалзан тогтооно.

6.17. Андеррайтер нь нийтэд санал болгон бонд гаргах үйл ажиллагааг хоёр удаа дараалан амжилттай зохион байгуулж чадаагүй нь тухайн этгээдийн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

6.18. Хороо энэ журмын 6.14-т заасан тайланг хүлээн авч, андеррайтер нь анхдагч зах зээлд бондыг амжилттай байршуулж, аливаа зөрчил гаргаагүй гэж үзвэл олон нийтэд мэдээлж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах

мэдэгдлийг, арилжаа эрхлэх байгууллагад бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг ажлын гурван өдөрт багтаан Хорооны даргын албан бичгээр тус тус хүргүүлнэ.

ДОЛОО. БОНД ГАРГАГЧ, ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД, ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Бонд гаргагч дараах эрхтэй:

- 7.1.1. нээлттэй бонд гаргагч нь андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүгийн түвшинг тогтоох;
- 7.1.2. Хорооны бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хүсэлт нь хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах;
- 7.1.3. нийтэд санал болгон гаргах бондыг тодорхой үнэ, хувь хэмжээгээр худалдан авах эрхийг гэрчлэх варрант гаргах;
- 7.1.4. компанийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох;
- 7.1.5. бондын танилцуулга, гэрээнд заасан бол нийтэд санал болгон гаргасан бондыг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авах;
- 7.1.6. энэ журмын 7.5.3, 7.5.4-т заасан арилжаа эрхлэх байгууллагын шаардлага нь үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд гомдол гаргах.

7.2. Бонд гаргагч нь дараах үүрэгтэй:

- 7.2.1. нээлттэй бонд гаргагч нь андеррайтертай гэрээ байгуулсан байх;
- 7.2.2. санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох бол зэрэглэл тогтооход шаардлагатай үнэн зөв, бүрэн мэдээллийг тухайн байгууллагад гарган өгөх;
- 7.2.3. Хорооноос бондын бүртгэлтэй холбоотой аливаа мэдээлэл хүргүүлэхийг шаардсан бол тодруулга, нэмэлт баримт бичгийг бонд гаргагч нь заасан хугацаанд Хороонд хүргүүлэх;
- 7.2.4. нээлттэй бонд гаргагч нь бондыг анхдагч зах зээлд амжилттай санал болгосон тохиолдолд ажлын таван өдрийн дотор тухайн гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болох эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ эсхүл мэдэгдлийг улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 7.2.5. холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
- 7.2.6. бондыг Хороонд бүртгүүлж, энэ журмын 6.2-т заасан хугацаа дууссанаас хойш тухайн бондыг нийтэд санал болгох тохиолдолд уг хугацаа дуусахаас ажлын 10 өдрөөс доошгүй хугацааны өмнө бондын танилцуулгыг шинэчлэн бүртгүүлэх хүсэлтийг арилжаа эрхлэх байгууллагад гаргаж, Хороонд мэдэгдэл хүргүүлэх;
- 7.2.7. нээлттэй бонд гаргагч нь зэрэглэл тогтоолгосон бол хагас жил, бүтэн жил тутам зэрэглэлийг шинэчлэх;
- 7.2.8. бонд гаргагчид гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол бондын танилцуулгад уг этгээдийн тодорхой, үнэн зөв, бүрэн, мэдээллийг тусгах;
- 7.2.9. бондын танилцуулга, гэрээнд заасан бол хөрөнгө оруулагчийн саналаар түүний бондыг хугацаанаас нь өмнө худалдан авах;

- 7.2.10. тухайн гаргасан бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хороонд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт зэрэг бусад баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компани дээрээ хадгалах.
- 7.3. Андеррайтер дараах эрхтэй:
 - 7.3.1. хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулан авах;
 - 7.3.2. бондыг анхдагч зах зээлд тодорхой хэмжээгээр багцлан стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгох, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн худалдан авах;
 - 7.3.3. үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бонд гаргагчийн тогтмол болон тухай бүр нийтэд мэдээлэл хүргэх үйлчилгээг үзүүлэх.
- 7.4. Андеррайтер дараах үүрэгтэй:
 - 7.4.1. бондын танилцуулгыг бэлтгэх, анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах, худалдах болон байршуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
 - 7.4.2. хоёр болон түүнээс дээш тооны андеррайтер хамтран синдикат хэлбэрээр ажиллах тохиолдолд тэргүүлэх болон туслах андеррайтерийн чиг үүрэг, хариуцлагыг оролцогч талуудын хооронд байгуулсан гэрээнд тодорхой тусгах;
 - 7.4.3. анхдагч зах зээлийн захиалга авах явцад харилцагчийг таньж мэдэх, аливаа сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх;
 - 7.4.4. Хороонд бүртгүүлсэн бондын танилцуулгыг нийтэд үнэ төлбөргүй хүргэх, сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангах;
 - 7.4.5. андеррайтер мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх;
 - 7.4.6. үйлчилгээ үзүүлсэн бонд гаргагчийн бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих;
 - 7.4.7. бонд гаргагч төлбөрийн чадваргүй болж, хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах.
- 7.5. Арилжаа эрхлэх байгууллага дараах эрхтэй:
 - 7.5.1. өөрийн баталсан бүртгэлийн журмын дагуу нийтэд санал болгох бондыг өөрийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах;
 - 7.5.2. бүртгэлийн нарийвчилсан шаардлага, шалгуурыг хууль, энэ журамд нийцүүлэн дараах байдлаар тогтоох;
 - 7.5.2.1. бонд гаргагчийн үйл ажиллагааны онцлог, салбар, цар хүрээ болон бусад хүчин зүйлтэй уялдуулан ангилалтайгаар тогтоох;
 - 7.5.2.2. үнэт цаас нь тухайн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй этгээдийн нийтэд санал болгон гаргах бондын бүртгэлд хөнгөвчилсөн шалгуур тогтоох.
 - 7.5.3. бондыг бүртгэхтэй холбоотой нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичиг шаардах;

- 7.5.4. бүртгэлийн шаардлага, шалгуур болон бондын танилцуулгын бүрдэл нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй, тооцоолол, судалгаа нь зөрүүтэй, бодит байдалд нийцээгүй тохиолдолд тухайн бондыг бүртгэхээс татгалзах;
- 7.5.5. бонд гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, бүртгэлийн шаардлагыг хангахгүй болсон бол бүртгэлээс хасах;
- 7.5.6. энэ журмын 7.5.5-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан бонд гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй бусад үнэт цаасыг бүртгэлээс хасах.
- 7.6. Арилжаа эрхлэх байгууллага дараах үүрэгтэй:

7.6.1. хууль, Хорооны журам болон бүртгэлийн шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг хянаж, тухайн бонд гаргагч, түүний гаргах бонд нь зохих шалгуурыг хангасан бол бондыг бүртгэх эсэх асуудлыг хамтын шийдвэрийн зарчмаар шийдвэрлэх;

7.6.2. бондыг бүртгэхтэй холбоотой хяналтын үйл ажиллагааг ажлын 15 өдрийн дотор гүйцэтгэх;

7.6.3. хяналтын үйл ажиллагааны явцад аливаа нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичиг шаардсан, эсхүл үндэслэл бүхий татгалзсан шийдвэр гаргасан бол бонд гаргагчид энэ тухай мэдэгдлийг албан бичгээр, хувийг тухай бүрд Хороонд тус тус хүргүүлэх;

7.6.4. бондыг бүртгэсэн бол шийдвэрийг дүгнэлт /Хавсралт 6/-ийн хамт ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх;

7.6.5. андеррайтерийн анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагаа нь бондын танилцуулгад заасан журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

7.6.6. Хорооноос хүргүүлсэн мэдэгдлийн үндсэнд бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх;

7.6.7. бондыг энэ журмын 7.5.5-д заасан болон бонд гаргагчийн хүсэлтээр бүртгэлээс хассан бол шийдвэр болон мэдэгдэл /Хавсралт 7/-ийг шаардлагатай бусад баримт бичгийн хамт ажлын хоёр өдөрт багтаан Хороонд хүргүүлэх.

